



**ХЭНТИЙ АЙМАГ
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/14

Бэрх

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн урьдчилсан үзлэг, тооллогыг явуулах тухай

Монгол улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, “Авто тээврийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Хэнтий аймгийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/12 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тус хотын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн техникийн урьдчилсан үзлэгийг 2026 оны 04 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга : Э.Мягмарсүрэн (ЗАА-ны дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Болорцэцэг (ЗАА-ны Татварын улсын байцаагч)

Гишүүд:

М.Түвшинбаяр (Батноров сумын Сум

дундын Цагдаагийн тасгийн замын цагдаагийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч)

Б.Наранбат (Батноров сумын Сум

дундын Цагдаагийн тасгийн цагдаа жолооч, цагдаагийн ахлагч)

Ш.Ганцэцэг (ЗАА-ны Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

3.Авто тээврийн хэрэгслийн техникийн урьдчилсан үзлэгийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4.Сумдад батлагдсан хуваарийн дагуу явагдсан авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Батноров сумын сум дундын цагдаагийн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цагдаагийн ахмад, (Б.Батхүү)-д даалгасугай.

5.Заагдсан хугацаанд авто тээврийн хэрэгслийн албан татварыг хураахыг Татварын улсын байцаагч (Б.Болорцэцэг), хуваарьт өдрүүдэд хэв журам сахиулах, албан хаагчдыг үүрэгжүүлж, хариуцлагатай ажиллуулахыг Батноров сумын сум

232 601 028

дундын Цагдаагийн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Цагдаагийн ахмад, (Б.Батхүү), Захирагчийн орлогч (Н.Бахыт) нарт тус тус үүрэг болгосугай.

6.Дээрх тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн урьдчилсан үзлэг, тооллогыг зохион байгуулж 2026 оны 04 дүгээр сарын 20-нд ажлын хэсгийн гишүүд илтгэх хуудсыг танилцуулахыг Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН